



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

9 сар
2022

Баруун-Урт сум



ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл	3
Аргачлалын тайлбар	4-5
Товч танилцуулга	6-15
Үндсэн үзүүлэлтүүд	16

I. Нийгмийн үзүүлэлт

I.1 Хөдөлмөр	17-19
I.2 Нийгмийн даатгал, нийгмийн халамж	20-21
I.3 Боловсрол	22-23
I.4 Эрүүл мэнд	23-25
I.5 Соёл, урлаг	25-26
I.6 Газар өмчлөл	26-27
I.7 Гэмт хэрэг	27-29

II. Эдийн засгийн үзүүлэлт

II.1 Мөнгө, банк, даатгал	29-30
II.2 Төрийн санхүү	30-33
II.3 Төсөл хөтөлбөр	33
II.4 Үнэ	34-35
II.5 Хөдөө аж ахуй	36-40
II.6 Аж үйлдвэр	41-43
II.7 Тээвэр	44



Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон үгийн тайлал:

Сумдын нэр:

АС Асгат	ТШ Түвшинширээ
БД Баяндэлгэр	ТЦ Түмэнцогт
ДА Дарьганга	УБ Уулбаян
МХ Мөнххаан	ХА Халзан
НА Наран	ЭЦ Эрдэнэцагаан
ОН Онгон	БУ Баруун-Урт
СҮ Сүхбаатар	

Төл гэсэн нь төлөвлөгөө, Гүйц гэсэн нь гүйцэтгэл юм.

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI, VII, VIII, IX ...г.м)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XI зэргээр илэрхийлэв.

III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

...	Мэдээлэл байхгүй	%	Хувь
0.0	Маш бага тоо	1	Дахин
-	Гүйцэтгэл байхгүй	мянга	1000
x	Бүтцийн өөрчлөлт	сая	106
+, -	Зөрүү	тэрбум	109
*	Урьдчилсан гүйцэтгэл	их наяд	1012

┌ "Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

IV. 22-21 нь 2022 оны үзүүлэлт тухайн оны үзүүлэлтээс өсч, буурсан абсолют өөрчлөлт.

V. Орон дэвшүүлэхээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас их, бага зэрэг зөрүүтэй байж болно.



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:** Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн хүмүүс орсон болно.
- **Тэтгэвэр, тэтгэмж:** Уг мэдээг нийгмийн даатгал, халамж үйлчилгээний хэлтсүүд нь гарган нэгтгэж ирүүлдэг.
- **Эрүүл мэнд:** Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
 - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
 - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Соёл, урлаг:** Соёл, урлагийн үйл ажиллагааг эрхэлдэг газрууд нь мэдээг нэгтгэн гаргаж ирүүлдэг.
- **Газар өмчлөгч:** Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь сумдаас мэдээллийг авч нэгтгэн ирүүлсний дагуу мэдээллийг хүргэдэг.
- **Гэмт хэрэг:** Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

- Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.
- Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдыг эд



хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.

- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.
- 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.
- **Хэрэглээний үнийн индекс / ХҮИ / гэдэг нь** хэрэглэгчдийн худалдаж авсан бараа үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.
 - Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- **Мөнгө, банк, даатгал:** Монгол банк арилжааны банкнуудаас мэдээг авч нэгтгэн, банкнуудын үндсэн материалын хамт ирүүлдэг. Даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд үндсэн үйл ажиллагааны мэдээллийг гаргаж ирүүлдэг.
- **Төсөл:** Засгийн газрын зарим гол төслүүд болон сангуудын хөрөнгийн зээл олголт, үйл ажиллагааны мэдээллийг холбогдох хэлтэс, агентлагууд гаргаж ирүүлдэг.
- **Төрийн санхүү:** Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймгийн нэгдсэн төсөв нь татварын болон татварын бус орлого, улсаас авах санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого, орон нутгийн сангийн орлогын шилжүүлэг зэргээс бүрдэнэ. Төсвийн мэдээг Санхүү төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
 - Аймгийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- **Хөдөө аж ахуй:** Газар тариалангийн эцсийн мэдээг багийн Засаг дарга нар өрхөөс цуглуулах ба аж ахуй нэгж байгууллагууд сумын тамгын газарт салбар хариуцсан ажилтанд өгч нэгтгэн ирүүлдэг.




• **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа Нэгдсэн үндэсний байгууллагын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.

- **Нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо:** гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2010 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.
- **Борлуулсан бүтээгдэхүүн** нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.
- **Гол нэр төрлийн** бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

**Сүхбаатар аймгийн нийгэм, эдийн засгийн байдал****I. Нийгмийн үзүүлэлт****I.1 Хүн ам**

Эрүүл мэндийн газраас гаргадаг мэдээгээр 2022 оны эхний 9 сард 809 хүүхэд шинээр мэндэлж, 236 хүн нас баржээ. Хүн амын цэвэр өсөлт 573 болж урьд оны мөн үеэс 222 (27.9%) хүнээр буурсан. 1000 хүнд ногдох төрөлт 12.4, нас баралт 3.7 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 4.6 пунктээр, нас баралт 0.7 пунктээр буурсан байна.


Зураг.I.1 Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо

**I.2 Хөдөлмөр**

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 2022 оны 9 дүгээр сарын эцэст 417 болсны 183 (43.9%) нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажил хайгчдын 352 нь ажилгүй иргэд байгаа нь өмнөх оны мөн үеэс 144 (29.0%) хүнээр буурсан байна.

Эхний 9 дүгээр сарын байдлаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 1606 ажилгүй иргэн шинээр бүртгүүлсний 313 (19.5%) иргэн ажилд зуучлагдан оржээ.

Зураг.I.2. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд





Ажилгүй иргэдийн 295 (83.8%) нь 15-44 насныхан эзэлж байгаа юм.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 66 (18.8%) нь бакалавр, 10 (2.8%) нь тусгай дунд, 24 (6.8%) нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 185 (52.6%) нь бүрэн дунд, 42 (11.9%) нь суурь, 20 (5.7%) нь бага боловсролтой, 5 (1.4%) боловсролгүй хүмүүс байна.

Зураг.1.3. Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшингээр



1.3 Нийгмийн даатгал, халамж:

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 13.7 тэрбум төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 2.1 (17.6%) тэрбум төгрөгөөр өсчээ.

Аймгийн хэмжээнд сайн дурын даатгуулагчид 1.3 тэрбум төгрөгийн шимтгэл төлж, өмнөх онтой харьцуулахад 0.3 (35.1%) тэрбум төгрөгөөр өсчээ. Нийт 9.5 мянган иргэнд 41.7 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосноос, 7.4 мянган өндөр настанд 32.9 тэрбум төгрөг, 1.4 мянган тахир дутуу иргэнд 4.7 тэрбум төгрөг, 0.4 мянган тэжээгчээ алдсан иргэнд 1.4 тэрбум төгрөг, 0.4 мянган иргэнд цэргийн тэтгэвэрт 2.6 тэрбум төгрөг, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчтөний даатгалаас 0.02 мянган иргэнд 0.1 тэрбум төгрөгийг тус тус бүрэн олгосон байна.

Нийт тэтгэвэр авагчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 431 (4.7%) хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 1.1 (35.8%) тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээгээр 9 сард 25.6 мянган иргэнд 8.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлт, тусламж, дэмжлэгийг олгосон байна. Үүнийг төрлөөр нь авч үзвэл: Улсын төсвөөс нийгмийн халамжийн тэтгэврийг 1.3 мянган иргэнд 3.2 тэрбум төгрөг, нийгмийн халамжийн тэтгэмжийг 2.2 мянган иргэнд 150.6 сая төгрөг, алдарт эхийн одонтой 5.3 мянган эхчүүдэд 1.7 тэрбум төгрөгийг, насны хишиг 2.8 мян иргэнд 0.5 тэрбум төгрөгийг, хүнс тэжээлийн хөтөлбөрт 3.1 иргэнд 0.2 тэрбум төгрөгийг, бусад хөнгөлөлт, тусламж, дэмжлэгт 10.9 мянган иргэнд 2.5 тэрбум төгрөгийг тус тус олгожээ.



I.4 Боловсрол

Ерөнхий боловсролын сургуульд 2022-2023 оны хичээлийн жилд урьдчилсан байдлаар 13.8 мянган суралцагчид байгаагийн 6.7 (50.1%) мянга нь эмэгтэй суралцагчид байна. Өмнөх оны мөн үеэс суралцагчдын тоо 386 (2.9%) хүүхдээр өсчээ.

Нийт суралцагчдын 6.7 (54.0%) мянга нь 1-5-р ангид, 4.4 (32.8%) мянга нь 6-9-р ангид, 1.8 (13.2%) мянга нь 10-12-р ангид суралцаж байна.

Энэ хичээлийн жилд 1-р ангид 1.4 мянган суралцагчид элсэн орсны 714 (49.4%) эмэгтэй суралцагчид байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 72 (4.7%) суралцагчаар буурсан байна. Мөн 12-р ангид 542 суралцагчид байгаагийн 307 (56.6%) нь эмэгтэй суралцагчид байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 48 (8.1%) суралцагчаар буурсан байна.

Энэ хичээлийн жилд 457 бүлэг хичээллэж байгаа бөгөөд нэг ангид 30.2 суралцагч ногдож байна. 1 багшид ногдох суралцагчийн тоо 21 байгаа нь өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна.

Нийт ажиллагсдын 645 (58.2%) үндсэн багш байна. Үүний 528 (81.9%) нь эмэгтэй багш нар байна. Өмнөх оны мөн үеэс багш нарын тоо 5 (0.8%) багшаар өссөн байна.

Дотуур байранд 966 сурагч амьдарч байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 97 (11.2%) сурагчаар өсчээ.

Зураг I.4.1 Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын тоо



Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв:

Сүхбаатар аймаг дахь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 2022-2023 оны хичээлийн жилд урьдчилсан байдлаар 15 мэргэжлээр 382 суралцагчид суралцаж байгаагийн 145 (38.0%) нь эмэгтэй суралцагчид байна. Өмнөх оны мөн үеэс нийт суралцагчдын тоо 74 (16.2%) суралцагчаар буурсан байна.



Нийт суралцагчдын 100 (26.2%) мэргэжлийн боловсрол эзэмшихээр 1 жилийн хугацаатай суралцаж байна.

Нийт суралцагчдын 54 (14.1%) барилгын засал чимэглэгч, 52 (13.6%) авто машины засварчин, 36 (9.4%) гоо засалч, 33 (8.6%) гар урлалын ажилтан, 27 (7.1%) төмөр замын барилгачин, 25 (7.3%) оёмол бүтээгдэхүүний оёдолчин, 25 (7.3%) бетон арматурчин гэх мэт мэргэжлээр сурч байгаа нь олонх байна.




I.5 Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд эхний 9 сарын байдлаар 178.4 мянган хүнд үзлэг хийсэн ба урьдчилан сэргийлэх үзлэгт 35.8 мянган хүн хамрагдаж, 11.0 мянган хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн байна. Өмнөх оны мөн үеэс нийт үзлэг 28.2 (18.8%) хүнээр өсч, урьдчилан сэргийлэх үзлэг 2.3 (2.5%) мянган хүнээр буурчээ.

Түргэн тусламжийн дуудлага 13.3 мянган удаа гарсны 2.5 (18.7%) мянга нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал алсын дуудлага 0.3 (10.7%) мянган хүнээр буурсан байна

Зураг.I.5.1 Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо



Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо эхний 9 сард 4.1 мянга болж, өмнөх оны мөн үеэс 2.9 (58%) мянган тохиолдлоор буурсан нь 2.9 (56%) мянганаар короновируст /ковид-19/ халдвар буурсан нь нөлөөлсөн байна.




I.6 Соёл, урлаг:


Хөгжимд жүжгийн театр: 3.0 мянган үзэгчдэд 13 тоглолтоор үйлчилж 6.4 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс үзэгчдийн тоо 3.5 дахин буурсан. Тоглолтын тоо 2.1 дахин, орлогын хэмжээ 4.2 дахин тус тус өсчээ.



Зураг I.6.1 Нийт тоглолтын тоо




Зураг I.6.2 Нийт үзэгчдийн тоо, мян.хүн




Музей: 2.3 мянган үзмэрээр 6.4 мянган хүнд үйлчилж 875.7 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үзэгчдийн тоо 21.3 дахин үзмэрийн тоо 1.4 хувиар өссөн байна.

Зураг I.6.3 Нийт үзмэрийн тоо




Зураг I.6.4 Нийт үзэгчдийн тоо, мян.хүн




Номын сан: Нийт 49.3 мянган номоор 6.8 мянган уншигчдад үйлчилжээ. Өмнөх оны мөн үеэс номын тоо 0.3 (0.6%) мянгаар өсч, уншигчдын тоо 5.8 мянган 6.8 дахин хүнээр өсчээ.

Зураг I.6.5 Нийт номын тоо



Зураг I.6.6 Нийт уншигчдын тоо мян.хүн







I.6 Газар өмчлөл:

Аймгийн хэмжээнд өссөн дүнгээр нийт 12.1 мянган иргэн газар өмчилж авахаар өргөдөл гаргаснаас 11.1 мянган иргэнд 1005.63 га газар өмчлүүлэх шийдвэр гараад хэрэгжиж байна.

Зураг I.6.1 Газар өмчлөх өргөдөл гаргасан иргэдийн тоо



Зураг I.6.2 Засаг даргын шийдвэр гарсан иргэдийн тоо



I.7 Гэмт хэрэг


Бүртгэгдсэн гэмт хэрэг 2022 оны 9 дүгээр сард 430 болж, өмнөх оноос 174 (67.9%)-өөр өсчээ.



Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 12 хүн нас барж, 121 хүн гэмтэж бэртсэн бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 11.9 тэрбум төгрөгийн хохирол учирсны 4.9 хувийг нөхөн төлүүлсэн байна. Гэмт хэрэгт 304 хүн холбогдон сэжиглэгдсэний 95 (31.3%) хүн нь согтуугаар хэрэг үйлджээ.

Нийт 327 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 46 (16.4%) хүнээр өссөн байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 166 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авахуулсан байна.

Зураг.I.7.1 Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо



II. Эдийн засгийн үзүүлэлт




II.1 Мөнгө, банк:

Монгол банкны мэдээллээр ХААН, Төрийн, Хас, Голомт банкнуудаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 197.6 тэрбум төгрөгт хүрсэн нь оны эхнээс 9.9 (5.3%) тэрбум, өмнөх оны мөн үеэс 25.8 (15.0%) тэрбум төгрөгөөр тус тус өсжээ.

Банкнуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 131.7 тэрбум төгрөгт хүрсэн нь оны эхнээс 2.4 (1.8%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 12.7 (8.8%) тэрбум төгрөгөөр буурсан тус тус буурсан байна. Чанаргүй зээлийн үлдэгдэл 9 дүгээр сарын эцэст 1.4 тэрбум болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.7 хувийг эзэлж байна.

Зураг.II.1. Зээлийн өрийн үлдэгдэл, хадгаламжийн үлдэгдэл, тэрбум.төг



Даатгал: Орон нутагт үйл ажиллагаагаа явуулж буй даатгалын байгууллагуудын хураамжийн орлого 1.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 628.5 (2.5 дахин) сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нөхөн төлбөр 1531 хүнд 224.3 сая төгрөг олгосны дотор авто тээврийн хэрэгсэлд 18.5 сая, жолоочийн хариуцлагад 93.1 сая, иргэдийн эд хөрөнгөнд 1.9 сая, гэнэтийн осолд 22.6 сая, хөдөлмөрийн чадвар түр алдалт 56.6 сая, хурдан морь унаач хүүхдийн даатгалд 26.6 сая төгрөгийг тус тус олгожээ.



Зураг. II.1.2 Даатгалын төрлөөр



II.2 Төрийн санхүү:


Аймгийн төсвийн нийт орлого 2022 оны эхний 9 сард 37.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 17.1 (31.5%) тэрбум төгрөгөөр, төсвийн зарлага санхүүжилт 34.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 15.1 (30.2%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Орон нутгийн төсөвт 7.8 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 1.7 (18.3%) тэрбум төгрөгөөр буурсан гүйцэтгэлтэй гарчээ.

Эхний хагас жилд Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 5.1 тэрбум төгрөг авсан нь өмнөх оны мөн үеэс 1.6 (24.3%) тэрбум төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг 8.6 тэрбум төгрөг авсан нь өмнөх оны мөн үеэс 1.0 (10.5%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн нийт хөрөнгө оруулалт 9 сард 7.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 3.0 (68.2%) тэрбум төгрөгөөр өсчээ.

Зураг. II.2. Төсвийн орлого, зарлага, тэрбум.төг



II.3 Төсөл хөтөлбөр: Аймгийн хэмжээнд олгосон төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлаар авч үзвэл: Хөгжлийн бэрхшээлтэй иргэний



ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хэмжээнд 14 иргэнд 90.0 сая, нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөрийн хэмжээнд 12 иргэнд 44.0 сая, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 24 иргэнд 100.0 сая, ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 21 иргэнд 187.0 сая, залуучуудын гарааны бизнес санхүүгийн дэмжлэгт 1 иргэнд 10.0 сая, мод тарих арга хэмжээнд 193 иргэнд 73.3 сая, малжуулах төсөл хөтөлбөрийн хэмжээнд 70 өрхөд 350.0 сая төгрөгийн төсөл санхүүжилтийг тус тус олгоод байна.




II.4 Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2022 оны 9 дүгээр сард өмнөх сараас 0.2 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 12.6 хувь, жилийн эцсээс 8.4 хувиар тус тус өссөн.

Зураг.II.4.1 Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны 12 сар=100)



Ерөнхий индекс жилийн эцсээс 8.4 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 10.7 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис 2.9 хувь, хувцас бөс барааны бүлгийн үнэ 7.9 хувь, орон сууц, цахилгаан, хийн болон бусад түлш 3.9 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 15.5 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 10.1 хувь, тээврийн бүлгийн үнэ 8.8 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 15.0 хувь, бусад бараа, үйлчилгээ 12.7 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.



Хүснэгт. II.4.1 Хэрэглээний үнийн үнийн индекс, бүлгээр

Бараа үйлчилгээний бүлэг	$\frac{2022.IX}{2021.IX}$	$\frac{2022.IX}{2021.XII}$	$\frac{2022.IX}{2021.VIII}$
Ерөнхий индекс	112.6	108.4	99.8
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	116.4	110.7	98.2
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	103.7	102.9	100.0
Хувцас, бөс бараа, гутал	114.5	107.9	101.1
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	105.7	103.9	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	120.3	115.5	100.2
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	111.4	110.1	100.9
Тээвэр	116.0	108.8	99.7
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.8	100.6	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	103.6	103.4	100.6
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	123.6	115.0	100.0
Даатгал санхүүгийн үйлчилгээ	100.0	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	118.3	112.7	100.2

**II.5 Хөдөө аж ахуй**

Мал төллөлт төл бойжилт. Оны эхний төллөх насны хээлтэгч малын 1558.0 (83.3%) мянган хээлтэгч мал төллөсөн байна. Таван төрлөөр нь авч үзвэл: эм хонь 84.8 хувь нь, эм ямаа 82.6 хувь нь, үнээ 79.5 хувь нь ингэ 45.9 хувь нь, гүү 78.4 хувь нь тус тус төллөжээ.

Гарсан төлийн 1547.8 (99.1%) мянган төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 134.7 (9.5%) мянган толгойгоор өссөн байна.


9 дүгээр сарын байдлаар төл бойжилтыг төрлөөр нь авч үзвэл: хурга 99.3 хувь, ишиг 98.7 хувь, унага 99.4 хувь, тугал 99.3 хувь, ботго 99.1 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.1-0.5 пунктээр тус тус өссөн байна.

Малын онд оролт: Том малын зүй хорогдол 2022 оны 9 дүгээр сард 13.4 толгой болж өмнөх оны мөн үеэс 29.5 мянган толгой буюу 68.8 хувь буурсан байна. Том малын хорогдлыг төрлөөр нь авч үзвэл: тэмээ 33 толгой, адуу 1476 толгой, үхэр 1526 толгой, хонь 4900 толгой, ямаа 5436 толгой байна. Нийт хорогдлын 36.6 хувийг хонь, 40.6 хувийг ямаа эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны 9 дүгээр сард 210 толгой мал өвчнөөр хорогдож нийт хорогдлын 1.6 хувийг эзэлж байна.



Зураг-II.4. Том малын зүй бус хорогдол



Ургац хураалт, хадлан бэлтгэл: Ургац хураалтын явцын мэдээгээр аймгийн хэмжээнд эхний 9 дүгээр сард 3.0 мянган тн үр тариа, 1.7 мянган тн тэжээлийн ургамал, 470.0 тн техникийн ургамал, 3.8 мянган тн өвс, 568.9 тэ төмс, 857.5 тн хүнсний ногоо бэлтгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс үр тариа 77.3 хувь, бэлгэсэн өвс 2.7 дахин, төмс 5.1 хувь, хүнсний ногоо 2.5 дахинаар тус тус өсч, тэжээлийн ургамал 57.4 хувь, техникийн ургамал 6.3 хувиар тус тус буурчээ.



II.5 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2010 оны зэрэгцүүлэх үнээр 35.9 тэрбум төгрөг болж өмнөх оноос 5.5 (13.3%) тэрбум төгрөгөөр буурчээ. Ангиллаар нь өмнөх онтой харьцуулан авч үзвэл: уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 5.7 (17.8%) тэрбум төгрөг буурч, боловсруулах аж үйлдвэрийнх 0.1 (3.0%) тэрбум төгрөг, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 0.1 (3.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Оны үнээр 270.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үеэс 95.5 (54.5%) тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс цайрын баяжмал, хайлуур жонш, дулаан, цахилгаан, бууз, банш, бялуу, талх, хэрчсэн гурил, үхрийн мах, хонины мах, ажлын болон тамирын хувцас, монгол дээл, тэрлэг, дээлнээс бусад монгол хувцас, гэрийн бүрээс туурга бусад хэрэгсэл, морины нэмнээ болон бусад хэрэгсэл, гэрийн бусад модон тавилга, бетон зуурмаг, хог хаягдал цуглуулах, зайлуулах, сувагжуулалт зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өмнөх оны мөн үеэс өссөн байна.



II.8 Тээвэр

Авто тээвэр бүхий байгууллагууд 3 дугаар улирлын байдлаар 148 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 8 (5.0%) мян.тн-оор буурсан байна. Бүтээгдэхүүн тээвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл: цайрын



баяжмал 22.0 мян.тн болж 30.0 хувиар өсч, нүүрс 16.0 мян.тн болж 43.2 хувиар буурсан байна.

Мөн давхардсан тоогоор 10.8 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс зорчигчдын тоо 0.2 (2.0%) мянган хүнээр буурчээ.

Авто тээврийн орлого 8.0 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.3 (4.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Т.ЭРДЭНЭБАТ



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эцсийн байдлаар

	Хэмжих нэгж	2020	2021	2022	Зөрүү	$\frac{2022}{2021}$ %
Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд						
Төрсөн хүүхэд	хүн	987	1 066	809	- 257	75.9
Нялхасын эндэгдэл	хүн	9	1	7	6	7.0 ¹
Бүртгэлтэй ажилгүй иргэд	хүн	508	496	417	- 79	84.1
Халдварт өвчнөөр өвчлөгчид	хүн	394	7 022	4 091	-2 931	58.3
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	300	256	430	174	168.0
Хэрэгт холбогсод	хүн	237	175	304	129	173.7
Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт						
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар	хувь	100.7	107.5	108.4	0.9	-
Иргэдийн хадгаламж	сая.төг	101 823.7	144 365.7	131 735.4	-12 630.3	91.3
Зээлийн өрийн үлдэгдэл	сая.төг	136 543.2	171 789.6	197 581.2	25 791.6	115.0
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	50 426.4	54 349.6	37 211.2	-17 138.4	68.5
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	50 768.2	49 860.7	34 799.3	-15 061.4	69.8
Төллөсөн хээлтэгч	тол	1 425 824	1 425 126	1 558 043	132 917	109.3
-Ингэ	тол	1 448	1 274	1 397	123	109.7
-Гүү	тол	79 850	84 289	91 748	7 459	108.8
-Үнээ	тол	81 949	87 158	96 344	9 186	110.5
-Эм хонь	тол	785 696	781 122	868 401	87 279	111.2
-Эм ямаа	тол	476 881	471 283	500 153	28 870	106.1
Бойжуулсан төл	тол	1 408 820	1 413 069	1 536 408	123 339	108.7
-Ботго	тол	1 413	1 259	1 385	126	110.0
-Унага	тол	78 975	83 670	91 186	7 516	109.0
-Тугал	тол	81 241	86 536	95 702	9 166	110.6
-Хурга	тол	777 481	776 621	864 066	87 445	111.3
-Ишиг	тол	469 710	464 982	495 482	30 500	106.6
Том малын зүй бусын хорогдол	тол	38 128	42 896	13 371	-29 525	31.2
- Тэмээ	тол	20	37	33	- 4	89.2
- Адуу	тол	1 377	1 994	1 476	- 518	74.0
- Үхэр	тол	2 645	4 395	1 526	-2 869	34.7
- Хонь	тол	18 497	16 934	4 900	-12 034	28.9
- Ямаа	тол	15 589	19 536	5 436	-14 100	27.8
Үүнээс: Өвчнөөр хоргдсон мал	тол	136	14	210	196	15.0 ¹
- Тэмээ	тол	-	-	-	-	-
- Адуу	тол	1	-	-	-	-
- Үхэр	тол	10	14	89	75	6.4 ¹
- Хонь	тол	60	-	56	-	-
- Ямаа	тол	65	-	65	-	-
Тариалсан талбай						
Үүнээс: Үр тариа	тн	1 730.0	1 691.0	2 999.0	1 308.0	177.4
Төмс	тн	561.7	541.5	568.9	27.4	105.1
Хүнсний ногоо	тн	303.5	344.9	857.5	512.6	2.5 ¹
Бэлтгэсэн өвс	тн	2 557.0	1 435.0	3 840.0	2405.0	2.7 ¹
Гар тэжээл	тн	-	785.0	-	-	-
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая.төг	31 124.0	41 425.0	35 934.6	-5 490.4	86.7
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая.төг	125 411.2	174 855.8	270 627.8	95 772.0	154.8

**I.2 ХӨДӨЛМӨР****I.2.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар**

Сум	2020		2021		2022	2022.IX 2021.IX %
	IX	XII	IX	XII	IX	
Асгат	3	10	8	8	3	37.5
Баяндэлгэр	27	9	30	51	7	23.3
Дарьганга	41	35	15	34	5	33.3
Мөнххаан	48	7	8	38	7	87.5
Наран	28	28	11	6	8	72.7
Онгон	26	11	15	37	11	73.3
Сүхбаатар	67	55	48	48	37	77.1
Түвшинширээ	26	57	46	83	69	150.0
Түмэнцогт	21	20	19	30	2	10.5
Уулбаян	70	32	38	10	12	31.6
Халзан	3	4	4	15	-	-
Эрдэнэцагаан	37	50	32	32	5	15.6
Баруун-Урт	111	144	222	171	186	83.8
Дүн	508	462	496	563	352	71.0

I.2.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, боловсрол, насны бүлгээр

Сум	Бүгд	эмэгтэй	Боловсролын түвшингээр								Насны бүлгээр					
			Магистр, доктор	Дээд боловсролтой	Тусгай дунд боловсролтой	Мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд боловсролтой	Суурь	Бага	Боловсролгүй	15-24	25-34	35-44	45-54	55-59	60+
Асгат	3	1	-	1	-	2	-	-	-	-	2	1	-	-	-	-
Баяндэлгэр	7	5	-	-	-	-	7	-	-	-	-	4	1	1	-	1
Дарьганга	5	2	-	1	1	-	3	-	-	-	-	4	1	-	-	-
Мөнххаан	7	6	-	2	-	-	4	-	1	-	1	3	1	1	-	1
Наран	8	5	-	-	2	-	5	1	-	-	-	3	3	1	1	-
Онгон	11	7	-	1	-	-	8	1	-	1	1	1	5	3	1	-
Сүхбаатар	37	16	-	2	1	5	21	5	3	-	9	15	8	4	1	-
Түвшинширээ	69	34	-	13	2	5	18	23	8	-	12	23	17	16	1	-
Түмэнцогт	2	2	-	-	-	-	2	-	-	-	2	-	-	-	-	-
Уулбаян	12	4	-	5	-	-	5	-	1	1	1	6	4	1	-	-
Халзан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	5	3	-	2	-	-	3	-	-	-	1	1	3	-	-	-
Баруун-Урт	186	68	-	39	4	12	109	12	7	3	29	73	60	17	7	-
Дүн	352	153	-	66	10	24	185	42	20	5	58	134	103	44	11	2



I.2.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар

Сум	2020		2021		2022	<u>2022.I-IX</u> 2021.I-IX %
	I-IX	I-XII	I-IX	I-XII	I-IX	
Асгат	14	30	75	95	63	84.0
Баяндэлгэр	120	156	100	193	20	20.0
Дарьганга	30	55	107	177	107	100.0
Мөнххаан	113	184	22	96	60	2.7 ¹
Наран	101	118	70	98	71	101.4
Онгон	77	122	59	141	20	33.9
Сүхбаатар	72	157	68	122	81	119.1
Түвшинширээ	144	228	126	258	250	198.4
Түмэнцогт	97	137	63	125	51	81.0
Уулбаян	143	158	94	124	46	48.9
Халзан	37	41	17	39	11	64.7
Эрдэнэцагаан	83	110	68	103	77	113.2
Баруун-Урт	424	783	773	1 018	749	96.9
Дүн	1 455	2 279	1 642	2 589	1 170	71.3

I.2.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮНИЙ ТОО, сумаар

Сум	2020		2021		2022	<u>2022.I-IX</u> 2021.I-IX %
	I-IX	I-XII	I-IX	I-XII	I-IX	
Асгат	4	9	46	52	43	93.5
Баяндэлгэр	38	65	5	35	2	40.0
Дарьганга	17	37	15	30	29	193.3
Мөнххаан	15	51	5	29	19	3.8 ¹
Наран	66	79	40	52	38	95.0
Онгон	10	43	8	49	-	-
Сүхбаатар	32	110	20	21	1	5.0
Түвшинширээ	49	69	37	81	66	178.4
Түмэнцогт	20	33	12	43	19	158.3
Уулбаян	48	52	20	37	18	90.0
Халзан	17	17	3	10	5	166.7
Эрдэнэцагаан	1	9	4	7	4	100.0
Баруун-Урт	44	272	114	161	69	60.5
Дүн	361	846	244	607	258	105.7

**I.2.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮНИЙ ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар**

Сум	Шинэ ажлын байранд орсон хүний тоо					Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар						
	2021. I-IX	2022.I-IX				Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	Уул уурхай, олборлолт	Боловсруулах үйлдвэрлэл	Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Бусад
		Бүгд	Үүнээс									
			Байнгын	Түр	Улирал							
Асгат	14	36	17	19	-	12	-	1	11	-	10	2
Баяндэлгэр	21	15	15	-	-	28	102	23	-	-	1	-
Дарьганга	23	15	14	-	1	13	-	2	-	-	-	-
Мөнххаан	5	37	27	10	-	12	-	2	1	-	-	-
Наран	10	21	19	-	2	31	-	5	-	-	-	1
Онгон	2	14	14	-	-	-	-	1	2	-	16	2
Сүхбаатар	8	43	18	25	-	9	-	5	-	-	-	-
Түвшинширээ	21	18	18	-	-	28	-	4	2	7	-	1
Түмэнцогт	13	17	17	-	-	8	-	1	4	-	-	5
Уулбаян	1	22	22	-	-	10	-	6	-	-	-	1
Халзан	8	19	11	8	-	11	3	3	-	-	5	-
Эрдэнэцагаан	1	19	19	-	-	15	-	2	-	-	2	-
Баруун-Урт	291	154	142	-	12	13	-	6	-	-	-	-
Дүн	418	430	353	62	15	190	105	61	20	7	34	12

**I.3 НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ****I.3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ, сумаар, сая.төг**

Сум	Нийгмийн даатгалын шимтгэл				Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого			
	2021.I-IX	2022.I-IX			2021.I-IX	2022.I-IX		
		Төл	Гүйц	%		Төл	Гүйц	%
Асгат	204.2	218.3	216.9	99.4	35.2	48.6	45.1	92.8
Баяндэлгэр	434.7	437.3	477.8	109.3	89.9	113.3	132.8	117.2
Дарьганга	299.3	312.7	346.4	110.8	50.2	89.0	69.1	77.6
Мөнххаан	337.5	384.2	411.0	107.0	85.8	113.3	96.2	84.9
Наран	181.8	193.8	199.7	103.0	38.4	60.7	59.8	98.5
Онгон	497.9	421.3	527.3	125.2	55.1	101.2	77.1	76.2
Сүхбаатар	305.7	345.3	311.4	90.2	67.7	93.1	84.5	90.8
Түвшинширээ	292.7	296.6	323.1	108.9	59.4	80.9	72.6	89.7
Түмэнцогт	438.6	548.9	466.7	85.0	34.3	52.6	47.3	89.9
Уулбаян	399.9	528.3	432.0	81.8	38.6	60.7	53.4	88.0
Халзан	204.5	207.9	216.8	104.3	19.2	40.5	34.0	84.0
Эрдэнэцагаан	728.7	717.1	807.5	112.6	137.6	182.1	194.8	107.0
Баруун-Урт	7 369.2	8 770.0	9 013.0	102.8	234.2	374.5	310.7	83.0
Дүн	11 694.7	13 381.7	13 749.6	102.7	945.6	1 410.5	1 277.4	90.6

I.3.2 ТЭТГЭВЭР ОЛГОЛТ, сумаар

Сум	Тэтгэвэр авагчдын тоо				Олгосон тэтгэвэр, сая.төг			
	2020.I-IX	2021.I-IX	2022.I-IX	%	2020.I-IX	2021.I-IX	2022.I-IX	%
Асгат	312	307	323	105.2	916.8	1 002.7	1 391.5	138.8
Баяндэлгэр	706	726	736	101.4	2 176.9	2 375.8	3 205.2	134.9
Дарьганга	445	460	485	105.4	1 297.3	1 479.3	2 035.7	137.6
Мөнххаан	586	576	612	106.3	1 748.3	1 866.3	2 587.3	138.6
Наран	244	245	267	109.0	751.7	833.8	1 191.1	142.9
Онгон	544	543	581	107.0	1 829.7	1 989.8	2 608.9	131.1
Сүхбаатар	427	421	470	111.6	1 267.8	1 391.8	1 969.0	141.5
Түвшинширээ	437	420	425	101.2	1 267.0	1 303.1	1 800.8	138.2
Түмэнцогт	401	391	409	104.6	1 231.0	1 315.4	1 801.5	137.0
Уулбаян	455	448	462	103.1	1 339.9	1 467.4	2 033.3	138.6
Халзан	235	238	257	108.0	694.4	793.7	1 128.6	142.2
Эрдэнэцагаан	870	959	925	96.5	2 828.4	3 053.9	4 168.1	136.5
Баруун-Урт	3 386	3 355	3 568	106.3	11 225.6	11 847.2	15 798.4	133.4
Дүн	9 048	9 089	9 520	104.7	28 574.8	30 720.2	41 719.4	135.8



I.3.3 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, сая.төг

Үзүүлэлт		2021.IX		2022.IX	
		Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг
Улсын төсөөс	1 Халамжийн тэтгэвэр	1 256	3 226	1 340	3 283
	2 Халамжийн тэтгэмж	2 179	1 496	2 213	1 571
	1. Асаргааны тэтгэмж	1 135	832	1 140	837
	байнгын асаргаа шаардлагатай				
	Ахмад настныг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	641	428	644	417
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	225	149	218	143
	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	225	226	234	242
	Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	17	11	18	15
	Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	7	7	5	7
	Хүүхэд, төрөл садангүй ганц бие ахмад настан болон ХБ иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалах	20	11	21	14
	3 Хүнс тэжээлийн хөтөлбөрийн зардал	5 739	543	3 099	227
	4 Ахмад настны нийгмийн хамгаалалын тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт тусламж	4 403	117	4 669	225
	5 Алдар цолтой ахмадуудад олгосон хөнгөлөлт тусламж	0	0	5	1
	6 ХБ-тэй иргэнд олгогдож буй хөнгөлөлт, тусламж	330	66	326	66
	7 Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	4 220	1 796	5 312	1 787
	0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж	3 389	1 414	3 936	1 431
	Жирэмсэн эхийн тэтгэмж	642	198	1 229	179
	Ихэр хүүхдийн тэтгэмж	15	30	7	14
	3 ба түүнээс дээш тооны хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд 1 удаа	174	154	140	164
Халамжийн сангаас	8 Насны хишиг	2 750	438	2 836	449
	9 Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж	5 473	722	5 659	736
	1 Амжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	1 044	665	1 073	733
	Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн	817	130	808	129
	16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	218	524	237	570
	18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	1	1	8	10
	Гэнэтийн аюулын улмаас орон гэргүй болсон өрхөд 1 удаа олгох тэтгэмж	7	8	15	18
	Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн	1	1	5	6
	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	46	31	172	63
	2				
ДҮН		26 396	8 435	25 626	8 406

**I.4 БОЛОВСРОЛ****I.4.1. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧДЫН ТОО**

Сум	Сургуулийн ангилал*	Нийт дүн					1-5-р анги			6-9-р анги		10-12-р анги			Үндсэн багшийн тоо*	1 багшид ногдох сурагчийн тоо*	Дотуур байранд амьдардаг сурагч*
		Бүлэг *	Бүх сурагчид*	Үүнээс: эмэгтэй*	Эмэгтэй хүүхдийн эзлэх хувь*	Нэг бүлэгт ногдох сурагч*	Бүх суралцагчид*	Бүгдээс: эмэгтэй*	Үүнээс: 1-р ангид*	Бүх суралцагчид*	Бүгдээс: эмэгтэй*	Бүх суралцагчид*	Бүгдээс: эмэгтэй*	Үүнээс: 12-р ангид*			
Ас	дунд	12	300	142	47	25	174	89	15	126	53	-	-	-	18	17	47
Бд	ахлах	36	1 097	552	50	30	535	272	55	407	186	155	94	29	48	23	121
Да	дунд	22	591	295	50	27	294	155	33	220	98	77	42	17	30	20	37
Мх	ахлах	35	1 009	523	52	29	505	260	48	353	177	151	86	22	50	20	74
На	дунд	10	278	152	55	28	176	97	24	102	55	-	-	-	16	17	46
Он	ахлах	28	739	356	48	26	360	158	30	268	129	111	69	33	37	20	32
Об	дунд	19	494	231	47	26	282	134	30	212	97	-	-	-	26	19	68
Тш	дунд	25	719	349	49	29	385	182	32	254	115	80	52	14	35	21	103
Тц	ахлах	22	539	269	50	25	270	127	19	188	92	81	50	12	32	17	52
Уб	дунд	18	451	205	45	25	248	115	20	203	90	-	-	-	23	20	74
Ха	дунд	10	226	123	54	23	140	73	19	86	50	-	-	-	14	16	55
Эц	ахлах	43	1 422	731	51	33	733	353	61	468	252	221	126	31	56	25	100
I БДС	ахлах	62	2 186	1 088	50	35	1 128	559	104	684	330	374	199	68	91	24	61
II БДС	ахлах	42	1 282	644	50	31	660	320	72	441	220	181	104	24	61	21	39
III БДС	ахлах	28	932	473	51	33	463	218	61	300	156	169	99	24	44	21	16
IV БДС	ахлах	45	1 516	767	51	34	802	404	91	482	227	232	136	33	64	24	41
Дүн		457	13 781	6 900	50	30	7 155	3 516	714	4 794	2 327	1 832	1 057	307	645	21	966
2 021		448	13 395	6 691	50	30	7 230	3 541	1 518	4 393	2 163	1 772	987	327	640	21	869
2 020		439	12 866	6 449	50	29	6 929	3 381	1 489	4 075	2 012	1 862	1 055	399	626	21	947
2 019		424	12 297	6 130	50	29	6 665	3 226	1 414	3 717	1 818	1 915	1 086	596	610	20	1 047
2 018		402	11 563	5 769	50	29	6 378	3 118	1 371	3 565	1 733	1 620	918	306	576	20	952
2 017		395	11 284	5 662	50	29	6 034	2 964	1 484	3 599	1 753	1 651	945	713	567	20	959
2 016		370	10 764	5 395	50	29	5 474	2 675	1 233	3 568	1 734	1 722	986	690	549	20	970



I.4.2. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 1, 12-Р АНГИД СУРАЛЦАГЧИД

Сум	1-р ангид				12-р ангид			
	2021-2022		2022-2023*		2021-2022		2022-2023*	
	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм
Ас	40	22	33	15	-	-	-	-
Бд	114	54	91	55	43	27	54	29
Да	64	30	55	33	29	15	27	17
Мх	107	56	93	48	49	31	42	22
На	38	14	36	24	-	-	-	-
Он	89	40	67	30	28	18	51	33
Сб	63	28	65	30	-	-	-	-
Тш	91	49	84	32	26	15	25	14
Тц	61	24	47	19	33	20	23	12
Уб	47	21	49	20	-	-	-	-
Ха	22	13	34	19	-	-	-	-
Эц	151	83	138	61	66	31	58	31
I БДС	252	123	209	104	144	69	124	68
II БДС	137	79	143	72	48	31	44	24
III БДС	74	33	127	61	63	34	39	24
IV БДС	168	88	175	91	61	36	55	33
ДҮН	1 518	757	1 446	714	590	327	542	307

I.4.3. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД АЖИЛЛАГСАДЫН ТОО

Сургуулиуд	Нийт ажиллагсад			Үндсэн багш			Сургалтын менежер			Нийт ажиллагсдын дотор үндсэн багшийн эзлэх хувь	
	2021-2022	2022-2023*		2021-2022	2022-2023*		2021-2022	2022-2023*		2021-2022	2022-2023*
		Бүгд	эм		Бүгд	эм		Бүгд	эм		
Ас	39	41	32	16	18	16	1	1	1	41.0	43.9
Бд	93	91	72	51	48	42	3	3	2	54.8	52.7
Да	53	53	42	30	30	24	2	2	2	56.6	56.6
Мх	91	89	69	52	50	42	3	3	3	57.1	56.2
На	35	38	26	15	16	13	1	1	1	42.9	42.1
Он	63	63	50	35	37	32	3	2	2	55.6	58.7
Сү	48	49	41	25	26	21	1	1	1	52.1	53.1
Тш	64	70	50	34	35	28	2	2	2	53.1	50.0
Тц	54	53	41	32	32	25	2	2	1	59.3	60.4
Уб	51	49	36	25	23	19	1	1	1	49.0	46.9
Ха	31	33	27	13	14	10	1	1	1	41.9	42.4
Эц	96	94	79	59	56	47	3	3	3	61.5	59.6
I БДС	131	134	101	91	91	71	4	4	4	69.5	67.9
II БДС	83	88	69	58	61	52	3	3	1	69.9	69.3
III БДС	65	69	55	41	44	35	3	3	3	63.1	63.8
IV БДС	91	94	73	63	64	51	3	3	2	69.2	68.1
дүн	1 088	1 108	863	640	645	528	36	35	30	58.8	58.2



I.4.4. СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН СУРАЛЦАГСДЫН ТОО

Үзүүлэлт	Суралцагчид			Мэргэжлийн боловсрол				
	2021-2022	2022-2023*	Үүнээс эмэгтэй	2021-2022	2022-2023*	Үүнээс эмэгтэй	I курс	Үүнээс эмэгтэй
Тогооч	53	22	18	53	22	18	-	-
Авто машины засварчин	30	52	-	30	52	-	27	-
Гагнуурчин	46	10	-	46	10	-	-	-
Модон эдлэлийн мужаан	25	13	-	25	13	-	-	-
Барилгын өрөг угсрагч	25	18	2	25	18	2	-	-
Барилгын засал чимэглэгч	68	54	19	68	54	19	27	6
Гоо засалч	19	36	35	19	36	35	21	20
Барилгын цахилгаанчин	45	21	1	45	21	1	-	-
Барилгын сантехникч	26	24	-	26	24	-	-	-
Бетон арматурчин	27	25	3	27	25	3	-	-
Оёмол бүтээгдэхүүний оёдолчин	30	25	24	30	25	24	-	-
Гар урлалын ажилтан	20	33	18	20	33	18	15	11
Ардын бүжгийн бүжигчин	12	-	-	12	-	-	-	-
Фермерийн аж ахуй	-	-	-	-	-	-	-	-
Төмөр замын барилгачин	30	27	12	30	27	12	-	-
Ойжуулагч	-	22	13	30	22	13	-	-
Бүгд	456	382	145	486	382	145	90	37

**I.5 ЭРҮҮЛ МЭНД****I.5.1 ЭРҮҮЛ МЭНД**

	Хэмжих нэгж	2021.I-IX	2022.I-IX	Өсөлт	
				тоо	хувь
1. Нийт үзлэг	мян.хүн	150.2	178.4	28.2	118.8
2. Ор хоног	мян.хүн	91.2	88.9	-2.3	97.5
3. Урьдчилан сэргийлэх үзлэг	мян.хүн	48.9	35.7	-13.2	73.0
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	10.7	11.0	0.3	102.8
5. Түргэн тусламжийн дуудлага	мян.хүн	12.4	13.3	0.9	107.3
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	2.8	2.5	-0.3	89.3
6. Осол гэмтлийн дуудлага	хүн	233	256	23.0	109.9
Нийт нас баралт	хүн	271	236	-35.0	87.1
8. Амаржсан эх	хүн	1 056	811	-245.0	76.8
Үүнээс: амьд төрсөн хүүхэд	хүн	1 066	809	-257.0	75.9
9. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	5	7	2.0	140.0
10. 1-5 хүртэлх насны эндсэн хүүхэд	хүн	1	4	3.0	4.0 ¹

I.5.2 ТӨРӨЛТ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар

Сум	Амаржсан эх	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
Асгат	-	-	1	-
